



## СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам,  
жагсаалт, төлбөрийн хэмжээ батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэг, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 49/A/118, Эрүүл мэндийн сайдын “Жагсаалт журам батлах тухай” 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/216, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн А/269, А/276 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Төлбөртэй тусламж үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”- ыг хоёрдугаар, “Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах журам”-ыг гуравдугаар, “Иргэнд үзүүлэх нэмэлт үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс хэрэгжүүлэн төвийн цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр хангах, төлбөртэй тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, чанар, хүртээмжтэй үзүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлзүй хариуцсан дэд захиралд, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг клиник, тасгийн эрхлэгч, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа хариуцсан дэд захиралд үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсан гарсантай холбогдуулан төвийн Захирлын 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/25 дугаар тушаал, 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/184 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.УУГАНЦЭЦЭГ

132630358

СЭМҮТ-ийн Захирлын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгчийн 2026 оны 05-р сарын 01-ны өдрийн  
А/63 дугаар тушаалын 1 хавсралт



## ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /цаашид СЭМҮТ гэх/- өөс Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээ болон Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт заасан төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй, төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журмын зорилго нь иргэн бүр шаардлагатай эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг санхүүгийн бэрхшээлгүйгээр авах, эрүүл мэндийн салбарын нийт зардалд иргэний шууд төлөх төлбөрийн эзлэх хэмжээг бууруулах, иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа шууд төлж буй төлбөрөөс үүдэлтэй санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэхэд оршино.

1.3 Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасан эмнэлгийн яаралтай, халдварт өвчний оношилгоо, эмчилгээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалтай эсэхээс үл хамаарч үзүүлэх бөгөөд энэхүү журамд хамаарахгүй.

1.4 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орсон тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлэх тохиолдолд эрүүл мэндийн даатгалд даатгуулахыг санал болгож, хэрэв татгалзсан тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг баримтлан төлбөр авч тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

1.5 СЭМҮТ-ийн үйл ажиллагааг дэмжих, хангах, туслах үйлчилгээ үзүүлдэг бүтээгдэхүүн үйлчилгээг энэхүү тушаалын хавсралтаар зохицуулна.

### Хоёр. Тусламж, үйлчилгээний зохицуулалт

2.1 СЭМҮТ төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлэхэд байгууллагын үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй, мөн үйлчлүүлэгчдэд хүндрэл үүсгэхгүйгээр зохицуулах арга хэмжээг авна.

2.2 СЭМҮТ лабораторийн тусламж, үйлчилгээний чанарын гадаад хяналтыг үндэсний лавлагаа лабораториор хийлгэх бөгөөд үйлчилгээний төлбөрийг Сангийн яамны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг баримтлан байгууллага хоорондын гэрээгээр зохицуулна.

2.3 СЭМҮТ нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын үзүүлэх тусламж,

үйлчилгээний жагсаалтад ороогүй үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр Сангийн яамны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг баримтлан нэмэлтээр үзүүлж болох бөгөөд нэмэлт үйлчилгээний төлбөрийг үйлчлүүлэгч өөрөө хариуцна.

2.4 СЭМҮТ нь эмнэлгийн нийт батлагдсан орны 15 хувиас хэтрэхгүйгээр иргэний хүсэлтийн дагуу тав тух хангасан төлбөртэй өрөөг ажиллуулж болох бөгөөд тасгуудад жигд хуваарилж, үйлчлүүлэгчид сонголтыг бий болгож, зохицуулалтыг хийнэ.

2.5 Энэхүү төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогод хамтын төлбөрийн орлого хамаарахгүй болно.

2.6 Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд СЭМҮТ нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй гадаадын иргэнээс энэхүү журмын 1.4-т заасныг баримтлан төлбөр авч тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

2.7 Төлбөртэй тусламж, үйлчилгээ авч байсан иргэн өөрийн хүсэлтээр төлбөртэй тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргасан тохиолдолд холбогдох зөвшөөрлийн хуудсыг бөглүүлж, тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртэл үзүүлсэн тусламж, үйлчилгээний төлбөрийг урьдчилан төлсөн төлбөрөөс хасагдуулж тооцон ямар нэгэн шимтгэл, хураамжгүйгээр төлбөр тооцоог хийж баримтжуулна. Урьдчилан төлөөгүй тохиолдолд иргэнээс бодит гарсан зардлаар төлбөрийг авна.

2.8 СЭМҮТ-өөс үзүүлж буй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед хийгдсэн үндсэн оношилгоо, шинжилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, материал, бариа засал, сэргээн засах эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ багтах бөгөөд энэхүү зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас болон иргэнээс давхардуулан авахгүй. Даатгуулагчийн хариуцан төлөх хамтын төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу шийдвэрлэнэ.

2.9 СЭМҮТ энэхүү тушаалын хоёр, дөрөвдүгээр хавсралтуудад заагдсан тусламж, үйлчилгээнээс бусад үйлчилгээнээс төлбөр авахыг хориглоно. Үүнд: ажлын бус цагаар үзүүлсэн тусламж, үйлчилгээ, шинжилгээний хариу өгөх, бие засах газар, нөмрөг, улавч, хувцас өлгөх, г.м нийтлэг үйлчилгээ хамаарна. Үйлчлүүлэгчийн автомашины зогсоол ашиглалтын төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд авахгүй.

2.10 Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, асаргаа, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.

2.11 СЭМҮТ энэхүү журмын хавсралтад заагдсан тусламж, үйлчилгээний нэр төрөл, цар хүрээг өргөтгөх замаар үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого нэмэгдүүлэх эх үүсвэр болгохгүй байх.

### **Гурав. Төлбөртэй тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал**

3.1 СЭМҮТ нь үйлчлүүлэгчийг төлбөртэй тусламж, үйлчилгээнээс хөнгөлөх нөхцөл болон санхүүгийн дэмжлэг, туслалцаа авах бусад боломжийн талаар ил тод мэдээллээр хангаж, үйлчлүүлэгчийг албан бус төлбөр төлөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

3.2 СЭМҮТ нь төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой дараах мэдээллийг мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим болон төлбөр хураах нэг цэгийн дэргэд иргэнд харагдахуйц, ойлгомжтой байдлаар байршуулах ба байгууллагын цахим хуудсанд байрлуулна. Үүнд:

3.2.1 Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ;

3.2.2 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх болон даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээ;

3.2.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зарим өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний жагсаалт, эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх болон даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээ

3.3 Иргэнээс энэхүү тушаалын хавсралтад заасан төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг авахдаа улсын төсвөөс болон эрүүл мэндийн даатгалын сангаас тухайн тусламж, үйлчилгээний төлбөрийг санхүүжүүлэхгүй байгаа шалтгааныг тайлбарлаж, иргэн зөвшөөрсний үндсэн дээр төлбөр авна.

3.4 СЭМҮТ нь иргэнд төлбөр төлсөн баримтыг (и-баримт) заавал олгох бөгөөд уг баримтад эрүүл мэндийн байгууллагын нэр, үйлчлүүлэгчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, холбогдох төлбөрийн хэмжээ болон нийт төлбөрийн хэмжээ, огноог дор дурдсанаар ялгасан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцсан тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, нэр төрөл бүрээр

- Иргэний хариуцан төлөх тусламж, үйлчилгээний хамтын төлбөрийн хэмжээ

- Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний төлбөрийн хэмжээ, нэр төрөл бүрээр

### **Дөрөв. Бусад**

4.1 Үйлчлүүлэгч СЭМҮТ-ийн төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн СЭМҮТ-ийн удирдлага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргах эрхтэй.

4.2 СЭМҮТ энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж, үйлчилгээнээс төлбөр авсан нь иргэний гомдлын мөрөөр, хөндлөнгийн хяналтын байгууллагын хяналт шалгалтаар нотолсон тохиолдолд СЭМҮТ иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцно.

4.3 Энэхүү тушаалын хавсралтаар баталсан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж, үйлчилгээг СЭМҮТ-ийн захирал, захирлын тушаалаар батлахгүй бөгөөд зайлшгүй шаардлагаар шинэ технологи, хөрөнгө оруулалтаар хийгдсэн тусламж, үйлчилгээ нэмэгдэх бол Эрүүл мэндийн яаманд холбогдох мэдээллийг албан бичгээр ирүүлж, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулж болно.

4.4 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт өөрчлөгдсөнөөс шалтгаалан эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, цалин, хөлс, урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын нөлөөллийг тооцож Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тухай бүр шинэчилж мөрдөнө.

4.5 СЭМҮТ-д ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын өөрөө болон өөрийн одоо амьдарч байгаа нөхөр, эхнэр, өөрийн үр хүүхэд, өөрийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, хадам эцэг, эх, СЭМҮТ-д ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудын нотлох баримт бичгийг үндэслэн төлбөрийн 50 хувиар хөнгөлөлт үзүүлнэ.

4.5.1 Дээрхи хөнгөлөлтийг СЭМҮТ-ийн үндсэн ажилтан жилд 2 удаа, ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд 1 удаа эдэлнэ.

4.5.2 Төлбөрийг хөнгөлөх зөвшөөрлийг Эмнэлзүй хариуцсан дэд захирал олгох бөгөөд Эмнэлзүй хариуцсан дэд захирлыг албан ёсоор амарсан, урт хугацааны чөлөөтэй байгаа үед орлож буй албан тушаалтан зөвшөөрлийг олгож, Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлал, Донтох эмгэг судлалын клиник, Яаралтай тусламжийн тасгийн хүлээн авах тасагт хэвтүүлэн эмчлэх, лабораторийн шинжилгээ хийх зэрэг асуудлыг шийднэ.

4.5.3 Хөнгөлөлт эдлэхэд дараах бичиг баримтыг үндэслэнэ.

- Эхнэр, нөхөр - төрийн албан хаагчийн анкет дахь бүртгэл

-Үр хүүхэд - төрийн албан хаагчийн анкет дахь бүртгэл, иргэний үнэмлэх /төрсний гэрчилгээ/

-Төрсөн ах, эгч, дүү - төрийн албан хаагчийн анкет дахь бүртгэл, ах, эгч, дүүгийн иргэний үнэмлэх

-Төрсөн эцэг, эх - төрийн албан хаагчийн анкет дахь бүртгэл, эцэг, эхийн иргэний үнэмлэх

-Хадам эцэг, эх - төрийн албан хаагчийн анкет дахь бүртгэл, гэрлэлтийн баталгаа, хадам эцэг, эхийн иргэний үнэмлэх

4.5.4 Сэтгэцийн эрүүл мэндийн албыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, хөрөнгө оруулалт хийсэн, харилцан хамтын ажиллагаатай Төрийн болон Төрийн бус байгууллагын зарим хүмүүст тавин хувь хөнгөлөлттэй тусламж, үйлчилгээ үзүүлэхийг Эмнэлзүй хариуцсан дэд захирал, зуун хувь хөнгөлөлттэй тусламж, үйлчилгээ үзүүлэхийг төвийн Захирлын зөвшөөрлөөр шийдвэрлэнэ.

**АЛБАН БАЙГУУЛЛАГАД ГЭРЭЭГЭЭР БОЛОН ИРГЭНД ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТЭЙ  
 ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ**

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр, төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
<b>Иргэнд үзүүлэх урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, оношилгоо</b>					
1.	Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, оношилгоо	Гэр бүл болох, ажил сургуульд орох зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдах (сэтгэцийн эмчийн үзлэг)	11101004	30.000
2.	Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, оношилгоо	Жолооны үнэмлэх авах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдах (сэтгэцийн эмчийн үзлэг)	11101005	20.000
3.	Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө	Буу галт зэвсэг эзэмших сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах (сэтгэцийн эмчийн үзлэг)	11101002	30.000
4.	Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө	Гадаад улсад явах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах (сэтгэцийн эмчийн үзлэг)	11101003	30.000
<b>Оношилгоо</b>					
5.	Лабораторийн шинжилгээ	Эмнэл зүйн шинжилгээ	Шээсэнд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бодис илрүүлэх шинжилгээ	10113021	30.000
6.	Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил, шинжилгээ	Сэтгэлзүйн оношилгоо, сорил	Сэтгэлзүйн оношилгоо, сорил (Бүх төрлийн насанд хүрэгчдийн болон хүүхдийн сорилууд)	10221001	30.000
<b>Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн тодорхойлолт гаргах үзлэг, оношилгоо (Аж ахуйн нэгж, албан байгууллагад гэрээгээр хийх урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ)</b>					

7.	Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээ	Багц-1	Сэтгэцийн эмчийн үзлэг 20.000 Сэтгэл зүйн оношилгоо QR сорил 25.000		55.000
8.		Багц-3	Сэтгэцийн эмчийн үзлэг 20.000 Сэтгэц идэвхт бодис /12 нэр төрөл/-ыг шээсэнд илрүүлэх 35.000		55.000
9.		Багц-4	Сэтгэцийн эмчийн үзлэг 20.000 Сэтгэл зүйн оношилгоо QR сорил 25.000 Сэтгэц идэвхт бодис /12 нэр төрөл/-ыг шээсэнд илрүүлэх 35.000		80.000
10.		Багц -5	Хүүхдийн сэтгэцийн эмчийн үзлэг /5-10 нас/ 20.000 Хүүхдийн оюуны түвшин тогтоох шинжилгээ 30.000		50.000
11.		Багц - 6	Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эмчийн үзлэг /11-17 нас/ 20.000 Сэтгэц идэвхт бодис /12 нэр төрөл/-ыг шээсэнд илрүүлэх 35.000		55.000
12.		Багц -7	Сэтгэцийн эмчийн үзлэг 20.000 Стрессийн түвшин тодорхойлох багажийн оношилгоо Dican AFT 800 аппарат 100.000		120.000
<b>Бусад тусламж үйлчилгээ</b>					
13.	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж, үйлчилгээ	Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын дүгнэлт гаргах	19901001	Анх удаа-30.000 Давтан 50.000
14.	Эмийн бус эмчилгээ	Сэтгэл заслын тусламж, үйлчилгээ	Бүх төрлийн сэтгэл засал (ганцаарчилсан, гэр бүлийн хосын, өөрөөс гаралтай дасгал)	10801001	50.000
15.	Багажийн оношилгоо (шинэ технологи)	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж, үйлчилгээ	Стрессийн түвшин тодорхойлох багажийн оношилгоо Dican AFT 800 аппарат		100.000
16.	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж, үйлчилгээ	1 шүдний цогц тусламж үйлчилгээ		52.000

17.	Шүдний өвчний ерөнхий үзлэг, оношилгоо, эмчилгээ	Амны хөндийн үйлчилгээ	Бүх шүдний өнгөлгөө хийх	10401005	15.000
18.	Шүдний өвчний ерөнхий үзлэг, оношилгоо, эмчилгээ	Амны хөндийн үйлчилгээ	Силант хийх	10401008	15.000
19.	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж, үйлчилгээ	Сэтгэл зүйн сургалт, мэдээлэл өгөх		1 багшид 45 мин-60.000

## **ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ ОЛСОН ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэхүү журам нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /цаашид эрүүл мэндийн байгууллага гэх/-аас үзүүлэх улсын төсвөөс хариуцах болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэнд төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлснээс бий болсон орлогыг зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь үйлчлүүлэгчид үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жагсаалтыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан төлбөрийн жишиг хэмжээ, жагсаалтад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй, код, ангиллыг өөрчлөхгүйгээр өөрийн байгууллагын үйлчилгээний хүрээнд тохируулан батална.

1.3 Нэмэлт тусламж, үйлчилгээ гэдэгт Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 24.3-т заасныг тус тус ойлгоно.

### **Хоёр. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогын бүртгэл, зарцуулалт**

2.1 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв буюу төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарцуулалтыг бодитой төлөвлөж, жил бүрийн төсөвтөө тусгаж Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын эрх үүргийн хүрээнд захиран зарцуулна.

2.2 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв буюу төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхэд оролцсон эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар, үйлчилгээ хийхтэй холбоотой гарах зардалд зарцуулна.

2.3 Үйлчлүүлэгчийг байгууллагын кассаар эсвэл цахимаар төлбөр төлөх бүхий л төрлийн боломжоор хангаж төлбөрийг төрийн сан дахь төсвийн үндсэн үйл ажиллагааны дансанд төвлөрүүлнэ.

2.4 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогыг байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэж, тайлагнаж ажиллана.

2.5 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв буюу төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь иргэнд төлбөр төлсөн баримтыг (и-баримт) заавал олгох бөгөөд уг баримтад байгууллагын нэр, үйлчлүүлэгчид үзүүлсэн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний нэр, төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

2.6 Энэ журамд заасан төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогын зарцуулалтын жилийн эцсийн тайланг дараа жилийн төсвийн төсөлтэй хамт Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.

### **Гурав. Эмч, эмнэлгийн ажилтны хориглох зүйл**

3.1 Эмч, эмнэлгийн ажилтанд дараах зүйлсийг хориглоно:

3.1.1 Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан төлбөрийн жишиг хэмжээнээс хэтэрсэн төлбөр нэхэмжлэхгүй байх;

3.1.2 СЭМҮТ-ийн ажлын үндсэн цагт багтаан үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг ажлын бус цагаар эсвэл бусад хэлбэрээр тохиролцон төлбөртэй үзүүлэх;

3.1.3 Үйлчлүүлэгчээс эрүүл мэндийн байгууллагын данснаас өөр дансанд болон бэлнээр үйлчилгээний төлбөр шилжүүлэхийг шаардах;

### **Дөрөв. Хяналт**

4.1 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй байх чиглэлээр төлбөрт үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийг байгууллагын дарга, захирал нар хүлээнэ.

4.2 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл болон төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд байгууллагын дотоод аудитын нэгж улирал бүр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дотоод аудитын нэгж жилд нэг удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана.

4.3 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал, төлбөрт үйлчилгээний орлогын зарцуулалтын талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг байгууллагын захирал хангаж ажиллана.

### **Тав. Хариуцлага**

5.1 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2 Иргэн эрүүл мэндийн байгууллагын нэмэлт үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн СЭМҮТ-ийн удирдлага, Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох байгууллагад гомдол гаргах эрхтэй.

5.3 Энэхүү тушаалыг зөрчиж, төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд СЭМҮТ иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулна.

5.4 Энэ журмын 5.3-т зааснаар иргэний төлбөрийг барагдуулсан бол Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд зааснаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

СЭМҮТ-ийн Захирлын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгчийн 2026 оны 05-р сарын 01-ны өдрийн  
А/63 дугаар тушаалын 4 хавсралт



**ИРГЭНД ҮЗҮҮЛЭХ НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр, төрөл	Төлбөртэй ажиллах клиник, тасаг	Код	1 хоногийн төлбөр
1.	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй ерөөний үйлчилгээ (люкс)	1 ортой	31401004	60.000
2.	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй ерөө (люкс)	2 ортой ерөө	31401005	40.000
3.	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй ерөө (Хагас люкс)	2-4 ортой ерөө	31401005	30.000
4.	Нэмэлт үйлчилгээ	Өвчтөн тээвэрлэх	Захиалгаар өвчтөн тээвэрлэх 1 км-т, яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд		31406001	2.000